

## ҮНИЙН САНАЛ АВАХ ЦАХИМ ТЕНДЕРИЙН УРИЛГА

Тендер шалгаруулалтын нэр:  
“Дүрэмт хувцас” нийлүүлэх цахим тендер  
Тендер шалгаруулалтын дугаар:  
**МХЕГ/201901018**

**Мэргэжлийн хяналтын ерөнхий газар** нь байгаль орчин, хилийн хяналтын улсын байцаагчдын дүрэмт хувцас нийлүүлэх цахим тендерт аж ахуйн нэгж байгууллагуудыг үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50000 (тавин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онд хийж гүйцэтгэсэн ажлын борлуулалтын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнтэй тэнцэхүйц байна.

2. **Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу аль нэг жилд нь санал болгож буй үнийн дүнтэй тэнцэхүйц, ижил төстэй бараа нийлүүлсэн байх.

Үнийн саналыг 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 10:00 цагаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 10:30 цагт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын **хурлын танхимд** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын тохируулагч агентлаг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жуулчдын гудамж, ЗГ-ын XII байр, 211 тоот өрөө, Утас: 263406**

Цахим хаяг: [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn), [www.pcsp.gov.mn](http://www.pcsp.gov.mn)